**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Сонгуулийн ерөнхий хорооны 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/15/НА-СТА-ТЕЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Долгоржав<br>Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn<br>Аудитор: Э.Булганчимэг<br>Утас: 261628 Цахим хаяг: bulganchimege@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1157

танай ______________-ны № ______________-т

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ДАРГА П.ДЭЛГЭРНАРАН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сонгуулийн ерөнхий хорооны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавры дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн болон дахин сонгуулийг 17 аймаг, 30 сум, нийслэлийн 1 дүүрэгт 2023 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн ням гарагт нэгдсэн журмаар зохион байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Сонгуулийн ерөнхий хороонд 15.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан бөгөөд сонгуулийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл болон түүний дагалдах хэрэгслийг нөхөн бүрдүүлэлт хийхээр 5 багц бүхий худалдан авалтыг хийсэн байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд 21 аймаг, 9 дүүрэгт сургагч багш бэлтгэх, “Хариуцлагатай сонгогч” сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр

боловсруулж 492.7 сая төгрөгийн санхүүжилт авч 122 удаагийн сургалт зохион байгуулан 491.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд туссан 1 хөтөлбөр, 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр зорилтот түвшнийг тусгажээ. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнгийн биелэлтийг 100.0 хувь гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2024\0425 SNAG-29.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,522,965.6** | **8,147,100.0** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **0.0** | **3,912,122.0** |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **0.0** | **94.9** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **2,522,965.6** | **4,234,883.1** |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,551,886.0** | **12,940,569.4** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,551,886.0** | **12,940,569.4** |
| 39200 | Биет хөрөнгө | 2,025,709.2 | 11,912,757.6 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 1,526,176.8 | 1,027,811.7 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,074,851.6** | **21,087,669.3** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.0** | **3,912,122.0** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.0** | **3,912,122.0** |
| 41300 | Өглөг | 0.0 | 3,912,122.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,074,851.6** | **17,175,547.3** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **6,074,851.6** | **17,175,547.3** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 14,410,826.1 | 14,410,826.1 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-8,335,974.5** | **2,764,721.3** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6,074,851.6** | **21,087,669.3** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,040,659.5** | **27,948,238.8** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,496,933.8** | **12,755,749.2** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,496,933.8 | **12,755,749.2** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,543,725.6** | **15,192,489.6** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **5,119,118.2** | **16,847,543.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,119,118.2** | **5,587,021.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,627,803.2** | **5,172,175.7** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 782,201.5 | 1,094,598.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 97,454.2 | 134,859.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,860.0 | 6,347.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 202,382.8 | 94,811.8 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 15,812.6 | 18,891.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 327,931.6 | 440,050.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,196,160.6 | 3,382,615.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,491,315.0** | **414,845.7** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.0** | **11,260,521.7** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **921,541.3** | **11,100,695.7** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **92,120.0** | **0.0** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **829,421.3** | **11,100,695.7** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,543,752.1** | **19,104,856.6** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **26.5** | **3,912,367.0** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | **26.5** | **3,912,367.0** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,543,725.6** | **15,192,489.6** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,543,752.1** | **3,932,212.9** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,543,752.1** | **3,932,212.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,052,437.2** | **3,517,367.2** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 782,201.5 | 1,094,598.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 97,454.2 | 134,859.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,860.0 | 6,347.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 69,588.4 | 45,191.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 15,662.6 | 18,891.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 332,378.0 | 444,096.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,749,292.6 | 1,773,382.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,491,315.0** | **414,845.7** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **-** | **15,172,643.7** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **-** | **11,260,521.7** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **11,260,521.7** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 11,260,521.7 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-** | **-11,260,521.7** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | - | **3,912,122.0** |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 3,912,122.0 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

| Д.д | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,245,430.4** | **0.0** | **5,245,430.4** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 1,267.7 | 0.0 | 1,267.7 |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,246,698.1** | **0.0** | **5,246,698.1** |
| 4 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | -1,267.7 | 0.0 | -1,267.7 |
| 5 | Тайлант үеийн үр дүн | 829,421.3 | 0.0 | 829,421.3 |
| 6 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **6,074,851.6** | **0.0** | **6,074,851.6** |
| 7 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 6,074,851.6 | 0.0 | 6,074,851.6 |
| 8 | Тайлант үеийн үр дүн | 11,100,695.7 | **0** | 11,100,695.7 |
| 9 | **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **17,175,547.3** | **0** | **17,175,547.3** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **20,391,744,600.00** | **14,325,186,732.79** | **6,066,557,867.21** | **70.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,424,644,600.00** | **3,064,664,999.91** | **1,359,979,600.09** | **69.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,378,695,900.00** | **3,025,708,523.91** | **1,352,987,376.09** | **69.1** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,171,399,200.00** | **1,052,407,494.47** | **118,991,705.53** | **89.8** |
| 210101 | Үндсэн цалин | 732,514,100.00 | 661,471,825.61 | **71,042,274.39** | **90.3** |
| 210102 | Нэмэгдэл | 351,242,200.00 | 245,756,221.29 | **105,485,978.71** | **70.0** |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 57,590,000.00 | 67,315,999.38 | **-9,725,999.38** | **116.9** |
| 210104 | Урамшуулал | 30,052,900.00 | 77,863,448.19 | **-47,810,548.19** | **259.1** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **146,424,800.00** | **129,895,441.10** | **16,529,358.90** | **88.7** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 99,568,900.00 | 89,779,541.67 | **9,789,358.33** | **90.2** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,713,900.00 | 10,562,613.10 | **1,151,286.90** | **90.2** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,371,200.00 | 8,397,950.87 | **973,249.13** | **89.6** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,342,800.00 | 1,915,993.15 | **426,806.85** | **81.8** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,428,000.00 | 19,239,342.31 | **4,188,657.69** | **82.1** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **8,072,300.00** | **6,347,000.00** | **1,725,300.00** | **78.6** |
| 210304 | Байрны түрээс | 8,072,300.00 | 6,347,000.00 | **1,725,300.00** | **78.6** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **47,448,800.00** | **45,190,991.85** | **2,257,808.15** | **95.2** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,581,300.00 | 4,125,300.00 | **-544,000.00** | **115.2** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,296,700.00 | 21,573,645.00 | **2,723,055.00** | **88.8** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,204,100.00 | 16,078,286.85 | **125,813.15** | **99.2** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,366,700.00 | 3,413,760.00 | **-47,060.00** | **101.4** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **22,598,000.00** | **18,891,814.00** | **3,706,186.00** | **83.6** |
| 210701 | Гадаад албан томилолт | 18,545,000.00 | 18,537,814.00 | **7,186.00** | **100.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,053,000.00 | 354,000.00 | **3,699,000.00** | **8.7** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн** | **481,648,300.00** | **444,096,197.00** | **37,552,103.00** | **92.2** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | | | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 470,787,600.00 | 441,834,137.00 | **28,953,463.00** | **93.8** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 10,048,000.00 | 1,512,760.00 | **8,535,240.00** | **15.1** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 190,000.00 | 171,000.00 | **19,000.00** | **90.0** |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 | **0.00** | **100.0** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 529,400.00 | 485,000.00 | **44,400.00** | **91.6** |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 27,300.00 | 27,300.00 | **0.00** | **100.0** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,501,104,500.00** | **1,328,879,585.49** | **1,172,224,914.51** | **53.1** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,497,814,700.00 | 1,325,610,051.09 | **1,172,204,648.91** | **53.1** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,289,800.00 | 3,269,534.40 | **20,265.60** | **99.4** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **45,948,700.00** | **38,956,476.00** | **6,992,224.00** | **84.8** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **34,925,000.00** | **34,605,706.00** | **319,294.00** | **99.1** |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 34,925,000.00 | 34,605,706.00 | **319,294.00** | **99.1** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **11,023,700.00** | **4,350,770.00** | **6,672,930.00** | **39.5** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,023,700.00 | 4,350,770.00 | **6,672,930.00** | **39.5** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **15,967,100,000.00** | **11,260,521,732.88** | **4,706,578,267.12** | **70.5** |
| 222001 | Тоног төхөөрөмж | 15,967,100,000.00 | 11,260,521,732.88 | **4,706,578,267.12** | **70.5** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **20,391,744,600.00** | **14,325,186,732.79** | **6,066,557,867.21** | **70.2** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **20,391,744,600.00** | **14,325,186,732.79** | **6,066,557,867.21** | **70.2** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 20,391,744,600.00 | 14,325,186,732.79 | **6,066,557,867.21** | **70.2** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **2** | **2** | **0** | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 2 | 2 | **0** | **100.0** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **35** | **35** | **0** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 4 | 4 | **0** | **100.0** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 31 | 31 | **0** | **100.0** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **35** | **35** | **0** | **100.0** |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | 33 | 33 | **0** | **100.0** |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 2 | 2 | **0** | **100.0** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **491,658,666.03** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **491,658,666.03** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **491,658,666.03** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **42,191,217.46** |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 42,191,217.46 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **4,964,437.57** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 4,964,437.57 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **444,503,011.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 444,503,011.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **491,658,666.03** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **491,658,666.03** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 491,658,666.03 |

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тайлант оны үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 0.2 | | | 1 | 0.2 | 1 | 0.2 | | | | |
| 2 | Санхүүгийн тайланд бэлтгэн нийлүүлэгчид төлөх санал тоолох машин, дагалдах хэрэгслийн 3,912.1 сая төгрөгийн өр төлбөрийг буруу бүртгэсэн байна. | 1 | 3,912.1 | | | 1 | 3,912.1 | 1 | 3,912.1 | | | | |
| | **Дүн** | **1** | **3,912.3** | | | **1** | **3,912.3** | **1** | **3,912.3** | | | | |

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д.д | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Иргэнд ажил гүйцэтгэх гэрээнд тусгаагүй 1.1 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг тооцож олгосон. | 1 | 1.1 | | | 1 | 1.1 | | | | | | |
| | **Дүн** | **1** | **1.1** | | | **1** | **1.1** | | | | | | |

### 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Д.д | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Хөдөлмөрийн дотоод журамд Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль,тогтоомж, дүрэм, журамд орсон өөрчлөлттэй нийцүүлэн (2014 оноос хойш) шинэчлээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| 2 | Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн улсын дугаарыг цэнхэр дэвсгэртэй болгож солиогүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| 3 | Шилэн дансны цахим хуудсанд батлагдсан орон тоонд орсон өөрчлөлттэй холбоотой мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй. | 1 | - | | | | | 1 | - |
| | **Нийт дүн** | **3** | **-** | | | | | **3** | **-** |